

**ТУСГАЙ ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ
ХЭЛЭЛЦСЭН ТАЛААР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Н.Энхболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгээс Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярыг оруулах тухай саналыг 2013 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Уг асуудлыг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах саналыг дэмжиж байгаагаа илэрхийлээд дэд хорооны гишүүдийн тоо 4 болж санал хоёр хоёроор тэнцэхээр болж байгааг анхаарах, цаашид гадаад орнуудын парламентын жишгээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнийг чуулганы нэгдсэн хуралдаанаас нууц санал хураалтаар сонгож байх зэрэг нэмэлт, өөрчлөлтүүдийг хийх шаардлага байгааг тэмдэглэн хэллээ.


Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасан журмын дагуу Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаярыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар гаргасан Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ЦОЛМОН

Төсөл
2013.12.03

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаярыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр баталсугай.

2. Энэ тогтоолыг 2013 оны 12 дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг